



“НОМИН КАРТ ББСБ” ХХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧИД

СҮЛД-АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Бага тойруу 8 дугаар хороо, 11-р
хороолол GB-центр #502 тоот
Утас:(976) 93098181, 99114056
E-mail: info@suld-audit.mn

2022.03.28 № 22/14
танай -ны №

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дүгнэлт

Бид “Номин карт ББСБ” ХХК Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн (цаашид “Компани” гэх) 2021 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бүхий санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар “Номин карт ББСБ” ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлага энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Монгол Улсын Аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай, зохистой үндэслэл болно гэж үзэж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудлууд гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлийн хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлсэн асуудлууд байдаг. Эдгээр асуудлыг бид санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ тайлангийн талаар аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн бөгөөд аудитор эдгээр асуудлаар тусад нь дүгнэлт өгдөггүй.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт санхүүгийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, үнэн зөв шударгаар толилуулах болон залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайлан бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайлан бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, компанийн чадамжийг үнэлж, тодруулах шаардлагатай бол компанийг татан буулгахаар, эсвэл ингэхээс өөр бодит хувилбар байхгүйгээр төлөвлөснөөс бусад тохиолдолд тасралтгүй ажиллагаатай холбоотой асуудал болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмыг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн Тайлангийн Аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт ул үндэстэйгээр нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Хүндэтгэсэн,
Сүлд-Аудит ХХК
Гүйцэтгэх Захирал, /МНБ/



Ч.ГҮНДБАЯР

**“НОМИН КАРТ ББСБ” ХХК-ИЙН
АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ТАЙЛАН
2021 оны 12 дугаар сарын 31-нээрх**

(төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	2020/12/31	2021/12/31
Хүүгийн орлого	1,165,362,756.16	1,230,433,349.33
Хүүгийн зардал	193,217,574.75	146,881,960.25
Цэвэр хүүгийн орлого	972,145,181.41	1,083,551,389.08
Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зөрүү	91,073,790.75	34,612,220.80
Бусад үйл ажиллагааны орлого	34,324,492.86	13,223,008.06
Хүүгийн бус орлогын нийт дүн	125,398,283.61	47,835,228.86
Үндсэн үйл ажиллагааны нийт орлогын дүн	1,097,543,465.02	1,131,386,617.94
Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал	28,267,303.20	25,876,658.24
Боловсон хүчний зардал	149,962,235.52	132,404,670.80
Бусад зардал	251,633,713.10	159,860,943.40
Хүүгийн бус зардлын дүн	429,863,251.82	318,142,272.44
Зээлийн эрсдэлийн зардал	127,667,401.43	73,906,634.54
Найдваргүй авлагын нөөц		25,000,000.00
Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал	540,012,811.77	714,337,710.95
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	12,355.49	3,285,829.31
Үндсэн бус үйл ажиллагааны зардал		8,542.00
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг/алдагдал	12,355.49	3,277,287.31
Татвар төлөхийн өмнөх цэвэр ашиг/алдагдал	540,025,167.26	717,614,998.26
Орлогын татварын зардал	50,736,534.63	9,379,823.94
Тайлант хугацааны цэвэр ашиг/алдагдал	489,288,632.63	708,235,174.32

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно.

